

2008 онд хөгжингүй улс орнуудын эдийн засгийн өсөлт саарсан ч Азийн хөгжиж буй орнуудын эдийн засаг өснө гэж АХБ үзэж байна

Хонгконг, БНХАУ (2008 оны 4 дүгээр сарын 2) – Аж үйлдвэр өндөр хөгжсөн томоохон улс орнуудын эдийн засгийн өсөлт буурсан, хүнсний бүтээгдэхүүн болон нефтийн үнэ нэмэгдсэн, АНУ-д зээлийн хямралтай байгаа ч гэсэн Ази тивийн хөгжиж буй улс орнуудын эдийн засаг 2008 онд дорвитой өсөх болно хэмээн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас саяхан гаргасан тайланд дурьдсан байна.

АХБ-наас Азийн орнуудын эдийн засгийн талаар урьдчилсан таамаглал дэвшүүлэн “*Азийн хөгжлийн төлөв*”(АХТ) тайланг жил бүр гаргадаг бөгөөд өнөөдөр гаргасан *2008 оны* тайланд Ази тивийн хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт 2008 онд 7.6 хувь, 2009 онд 7.8 хувиар тус тус өснө хэмээн тооцоолжээ. 2007 онд тухайн бүс нутгийн орнуудын эдийн засаг дунджаар 8.7 хувь өссөн бөгөөд энэ нь сүүлийн 20 жилийн хамгийн өндөр өсөлт байсан байна.

“Дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал нь Ази тивийн орнуудын эдийн засагт тодорхой хэмжээгээр нөлөөлөх боловч энэхүү нөлөөл нь тийм ч хүчтэй биш байна. Худалдааны уламжлалт суваг болон улам бүр эрчимжиж буй олон улсын санхүүгийн зах зээлийн интеграцчлалаар дамжуулан Ази тив дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаатай нягт холбоотой хэвээр байх болно” гэж АХБ-ны ахлах эдийн засагч Ифзал Али мэдэгдэв.

Мөн бодлогын тааламжтай нөхцөл болон Азийн эдийн засгийн шинэчлэл ба бүтцийн өөрчлөлтийн шилжилттэй уялдсан үйлдвэрлэлийн үсрэнгүй өсөлт нь бүс нутгийн хурдацтай өсөх нөхцлийг хангана гэжээ.

Азид инфляци хөөрөгдөх эрсдэл байна гэдгийг анхааруулж, шийдвэр гаргагчдыг энэхүү явцыг анхааралтай ажиглаж байхыг уриалж байна. Хэдийгээр үнийн өсөлтөөс хамгаалсан арга хэмжээ авч, төсвөөс татаас үзүүлж байгаа боловч 2008 онд инфляци огцом өсөх магадлалтай байгаа бөгөөд бүсийн хэмжээнд 10 жилийн турш байгаагүй өндөр түвшинд хүрч магадгүй байна гэдгийг дээрхи тайланд (АХТ)-д дурьджээ.

2008 онд Азийн орнуудын дундаж инфляцийн түвшин 5.1 хувь хүртэл өсөх магадлалтай байгаа ба цаашид бага зэрэг буурч 2009 онд 4.6 хувьд хүрнэ гэжээ. Төв Азид үнийн өсөлт хамгийн өндөр байх бөгөөд хоёр оронтой тоогоор хэмжигдэх болно. Инфляци БНХАУ-д сүүлийн 11 жилийн дунджаас хамгийн өндөр байх бөгөөд энэ нь Вьетнам зэрэг улсуудад сөрөгөөр нөлөөлнө.

Бодлогын шийдвэр гаргагчдад инфляцийн өсөлтийн шалтгааныг тогтоон шийдвэрлэхийг зөвлөсөн байна. Зарим улсууд гадаад валютын ханшийг уян хатан байлгах, нөгөө хэсэг нь төсвийн зардал болон тэргүүлэх чиглэлээ эргэн харах шаардлагатай байхад заримд нь зардлыг нэмэгдүүлж байгаа нийлүүлэлтийн дарамтыг багасгах зэрэг зорилтот арга хэмжээнүүд авах жишээтэй байна.

Энэ бүсийн томоохон улс орнууд болох БНХАУ болон Энэтхэг улсын засгийн газар өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хязгаарлах болон инфляцийн дарамтыг багасгах бодлого баримталж байгаа учир эдгээр орнуудын эдийн засгийн өсөлт нь саармагжих төлөвтэй байна.

БНХАУ-ын эдийн засаг 2008 онд 10 хувиар өсөх төлөвтэй байгаа ба Энэтхэгийн эдийн засгийн өсөлт нь 8 хувиар байх магадлалтай байна. БНХАУ-ын АНУ, Европын холбоо болон Япон зэрэг орнуудтай хийдэг худалдааны бараа эргэлт нь Энэтхэгийнхээс илүү байдаг тул дээрхи орнуудын эдийн засгийн өсөлт буурч байгаа нь БНХАУ-д илүү нөлөөлөхөөр байна.

АХБ-ны хэвлэлийн мэдээ 2008.4.02
Хуудас 2

Зүүн Ази дахь эдийн засгийн өсөлт нь 2007 оны 9.3 хувиас буурч, 2008 онд 8.1 хувиар өсөх төлөвтэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч байгаатай холбогдон экспортын хэмжээ буурах магадлалтай байгаа тул Зүүн Өмнөд Азийн улс орнуудын эдийн засаг 2007 оны 6.5 хувийн өсөлтөөс буурч 2008 онд 5.7 хувьд хүрэх төлөвтэй байна. Улс төрийн ээдрээтэй байдлаа шийдэж чадвал Зүүн Өмнөд Азийн орнуудаас зөвхөн Тайланд улс эдийн засгийн өндөр өсөлтөө хадгалсаар байх төлөвтэй байна. Вьетнамын хувьд инфляцийг бууруулах талаар арга хэмжээ авсны үр дүнд эдийн засгийн өсөлт нь бага зэрэг саарах шинжтэй байна.

Энэтхэгийн эдийн засгийн өсөлт удаашрахын хирээр 2008 онд Өмнөд Азийн улс орнуудын эдийн засаг нь мөн буурах хандлагатай болж байна. Бэлэн хувцасны үндсэн хэрэглэгч томоохон улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч байгаа нь Пакистан, Бангладеш, Шри Ланк улсуудын эдийн засагт сөрөгөөр нөлөөлөх төлөвтэй байна.

Төв Азийн улсуудын эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор хэмжигдэж байсан өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ бүс нутгийн хамгийн том эдийн засагтай улс болох Казахстаны эдийн засгийн өсөлтийн удаашралаас шалтгаалан огцом буурч, 2008 онд 7.5 хувьтай байх төлөвтэй байна. Казахстаны банкуудад орж ирэх хөрөнгийн урсгал гэнэт зогссоноос шалтгаалан түүхий нефтийн нөөцгүй улс орнуудад олгох зээлийн хэмжээ буурч улмаар тэдгээрийн эдийн засагт сөрөгөөр нөлөөлсөн байна.

Номхон далайн арлуудын бүс нутгийн хамгийн том эдийн засагтай улс болох Папуа Шинэ Гвиней дэлхийн зах зээл дээрхи түүхий эдийн өндөр үнээс ашиг олж байгаатай тул арлын улс орнуудын эдийн засаг 2008 онд өсөх хандлагатай байгаа ба Фижи арлын улсын эдийн засаг ч 2007 оны уналттай харьцуулахад өсөх төлөвтэй байна.

“Урт хугацаанд Азийн улс орнуудын өсөлтийн төлөв байдал нь тухайн улс орнууд өөрсдийн өмнө тулгарч буй бүтцийн өөрчлөлттэй холбоотой саад бэрхшээлүүдийг хэрхэн амжилттай даван туулахаас хамаарна” гэж ноён Али хэлж байна. Тэдгээр нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, дэлхийн эдийн засгийн интеграцчилалд нэгдэх, үнийн зохистой бодлого баримтлах, бизнесийн болон хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгох, эдийн засгийн өсөлтийн ашгийг хүн бүрт хүртээх боломжоор хангах зэрэг болно.

АХБ нь нийгмийн эмзэг давхрагын хүмүүст ээлтэй эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил, сайн засаглалаар дамжуулан Ази, Номхон далайн бүс нутагт ядуурлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон талт санхүүгийн байгууллага юм. АХБ 1966 онд байгуулагдсан бөгөөд 67 гишүүн оронтой, тэдгээрийн 48 нь тус бүс нутагт оршдог улс орнууд юм. 2007 оны байдлаар тус банкнаас нийтдээ 10,1 тэрбум ам долларын зээл, 673 сая ам долларын буцалтгүй тусламж, 243 сая долларын техник туслалцааны төслийн санхүүжилтийг гишүүн орнууддаа олгожээ.

Мүгүүгээр олох арга: media@adb.org

Omana Nair
T: +63 2 632 5178
M: +63 918 914 7003
E-mail: onair@adb.org

Sabyasachi Mitra
T: +63 2 632 4139
M: +63 918 939 9069
E-mail: sabymitra@adb.org

АОА-ийг үгээр олох арга: www.adb.org

ADB Online Media Center: media.adb.org
ADB web site: www.adb.org
Монгол хувийг: www.adb.org/mnrm
вэбсайтаас тус тус авна уу.

АХБ-ны хэвлэлийн мэдээ 2008.4.02
Хуудас 3

Азийн хөгжлийн урьдчилсан төлөв 2008

Улс орнуудын өсөлтийн хувь ба урьдчилсан төлөв

ДНБ-ний өсөлтийн хувь (% жилээр)	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Төв Ази	9.2	9.3	11.6	13.2	11.6	7.5	8.4
Армени	14.0	10.5	13.9	13.3	13.7	10.0	8.0
Азербайжан	10.4	10.2	29.6	33.4	25.4	15.7	18.0
Гурж	11.1	5.9	9.6	9.4	12.0	6.5	7.0
Казахстан	9.3	9.6	9.7	10.7	8.5	5.0	6.3
Киргиз	7.0	7.0	-0.2	3.1	8.2	7.6	7.6
Тажикстан	10.2	10.6	6.7	7.0	7.8	8.0	8.0
Туркменистан	17.1	14.7	9.0	9.0	10.0	10.0	10.0
Узбекистан	4.4	7.7	7.0	7.2	9.5	7.8	7.2
Зүүн Ази	7.3	8.4	8.3	9.1	9.3	8.1	8.2
БНХАУ	10.0	10.1	10.4	11.1	11.4	10.0	9.8
Хонг Конг, Хятад	3.0	8.5	7.1	7.0	6.3	4.5	4.8
БНСУ	3.1	4.7	4.2	5.1	5.0	5.0	5.2
Монгол	5.4	13.3	7.6	8.6	9.9	9.5	9.0
Тайпей, Хятад	3.5	6.3	4.2	4.9	5.7	4.2	5.6
Өмнөд Ази	7.8	7.3	9.0	9.0	8.4	7.6	8.1
Афганистан	15.1	9.4	16.4	6.1	13.9	9.0	9.0
Бангладеш	5.3	6.3	6.0	6.6	6.5	6.0	6.5
Бутан	9.0	7.0	6.9	7.8	17.0	14.4	7.2
Энэтхэг	8.5	7.5	9.4	9.6	8.7	8.0	8.5
Мальдив	8.5	9.5	-4.6	19.1	6.6	8.0	7.0
Балба	3.8	4.4	2.9	3.1	2.3	3.8	4.3
Пакистан	4.7	7.5	9.0	6.6	7.0	6.3	6.5
Шри Ланка	5.9	5.4	6.2	7.7	6.7	6.0	6.0
Зүүн-Өмнөд Ази	5.4	6.5	5.7	6.0	6.5	5.7	6.0
Камбож	8.5	10.0	13.5	10.8	9.6	7.5	7.0
Индонези	4.8	5.0	5.7	5.5	6.3	6.0	6.2
БНЛАУ	5.8	6.9	7.3	8.3	8.0	7.7	7.8
Малайзи	5.8	6.8	5.0	5.9	6.3	5.4	5.9
Мянмар	13.8	13.6	13.6	12.7	-	-	-
Филиппин	4.9	6.4	4.9	5.4	7.3	6.0	6.2
Сингапур	3.5	9.0	7.3	8.2	7.7	5.2	5.8
Тайланд	7.1	6.3	4.5	5.1	4.8	5.0	5.2
Вьетнам	7.3	7.8	8.4	8.2	8.5	7.0	8.1
Номхон Далайн бүс	2.1	3.8	2.9	2.3	3.1	4.4	3.3
Күүкийн арлууд	8.2	4.3	0.2	1.4	3.0	3.5	3.5
Фижи арал	1.1	5.4	0.7	3.6	-3.9	1.6	1.6
Кирибати	-1.5	2.3	2.5	1.1	0.5	1.0	1.0
Маршалын арлууд, БН Улс	3.4	5.6	1.7	1.3	2.0	1.0	1.0
Микронези, Холбооны БН	2.9	-3.3	-0.6	-2.3	-2.5	-3.5	-3.0
Науру	-	-	-14.5	6.3	-27.3	-2.4	-4.4
Палау, БНАУ	0.6	6.0	5.3	5.4	5.7	2.0	3.0
Папуа, Шинэ Гвиней	2.2	2.7	3.4	2.6	6.2	6.6	4.6
Самоа	3.1	3.3	5.1	2.6	4.0	3.0	3.0
Соломоны арлууд	6.4	8.0	5.0	6.1	10.0	6.0	2.5
Зүүн Тиморын БНАУ	0.1	4.1	6.2	-5.8	7.8	6.5	4.9
Тонга	3.2	1.4	2.3	1.9	-3.5	1.0	2.0
Тувалу	4.0	4.0	2.0	1.0	2.0	2.0	2.0
Вануату	3.2	5.5	6.5	7.2	6.6	5.7	4.3
Дундаж	7.1	7.9	8.1	8.6	8.7	7.6	7.8